



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

Залуучуудын гудамж-01, Баянмөнх баг, Хэрлэн сум,
Чингис хот, Хэнтий аймаг, 23117
Утас/Факс: (976) 7056 2412
Цахим шуудан: infoazdtg@khentii.gov.mn

2023.04.06 № 7/672
танай _____-ны № _____-г

ГАЗРЫН ХАРИЛЦАА
БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН
ГАЗРЫН ДАРГА Б.СҮНГЭЭ ТАНАА

Дүгнэлт, зөвлөмж хүргүүлэх тухай

Аймгийн Засаг даргын даргын баталсан удирдамжийн дагуу 2023 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр тус байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөн туслах үйл ажиллагаа хийсэн дүнг удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулж дараах дүгнэлт, зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

Дүгнэлт: Барилга, хот байгуулалтын яамнаас ирүүлсэн хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн жагсаалтын дагуу дээд газартаа тайлагнадаг, аймгийн Засаг даргын хэрэгжүүлэх хууль тогтоомж, тогтоол шийдвэрүүдийг хяналтад аваагүйн улмаас аймгийн Засаг даргын Тамгын газраас ирүүлсэн тайлангийн маягтын дагуу тухайн үед нь тайланг гаргаж явуулдаг, бүртгэл байхгүй, хяналтад аваагүй.

2023 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн заалтыг нарийвчлан тусгаагүй. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийг тайлагнахаар оруулсан боловч нэгж, албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хэн хариуцаж тайлагнах талаар бүрэн тусгаагүй.

Салбарын сайдтай аймгийн Засаг даргын байгуулсан гэрээний зарим заалтыг орхигдуулсан. Шалгуур үзүүлэлт, суурь түвшин, хүрэх түвшинг алдаатай оруулсан.

Зарим мэргэжилтнүүд гүйцэтгэлийн төлөвлөгөөг Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын дагуу зөв хийсэн боловч байгууллага, нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг задлалгүй шууд хуулж тавьсан байна.

Аймгийн Засаг даргын 2021 оны А/105 дугаар захирамжийн хавсралтын дагуу сумдаас тайланг авч үнэлж, дүгнэх ажил хийгдээгүй.

2.

Байгууллагын үйлчилгээний стандартын дагуу бүгд энгэрийн тэмдэг ажлын хувцастай байсан боловч өрөө тасалгааны эмх цэгц, байгууллагын цэвэр цэмцгэр байдал хангалтгүй урд нь хийсэн хяналт шалгалтын зөвлөмж дээр анхаарал хандуулаагүй.

12 албан хаагчийн хувийн хэрэгтэй танилцахад 2019 оны 04 дүгээр сарын 15-наас хойш хувийн хэргийг шинэчлээгүй байна.

Зөвлөмж:

1. Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн холбогдох заалтуудыг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 10.7-д заасны дагуу хяналтад авч, жил бүр жагсаалтыг шинэчлэн агентлагийн даргаар батлуулан хэрэгжилтийг хангаж ажиллах (үйл ажиллагаа нь тогтмолжсон хэрэгжилтийг нь хангадаг хүчингүй болоогүй хууль тогтоомж, тогтоол шийдвэрээ хяналтдаа авах)

2. Аймгийн Засаг даргын 2021 оны А/105 дугаар захирамжийг хэрэгжүүлж, ажиллах (сумдаас хагас, бүтэн жилээр тайланг авч дүн шинжилгээ хийж, дүгнэж байх)

3. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан үндсэн болон хамтран хэрэгжүүлэх хамааралтай заалтуудыг нэмж тусгах

4. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хариуцах нэгж, эзэнг тодорхой болгож, холбогдох мэргэжилтнүүд хариуцсан ажлаа бүгдийг албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгах бөгөөд өөрийн хийх арга хэмжээ болгон задалж оруулах

5. Гүйцэтгэлийн төлөвлөгөөг буруу боловсруулсан мэргэжилтнүүд Аргачлал, загвар батлах тухай Засгийн газрын хэрэг эрхлэх газрын 2020 оны 100 дугаар тушаалыг уншиж танилцан дахин боловсруулах

6. Шалгуур үзүүлэлтийг зөв тодорхойлж, хүрэх түвшинг суурь түвшинтэй уялдуулах (өмнөх оны суурь түвшинг авч байх)

7. Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилтын хүрээнд “Алсын хараа-2050” сургалт болон “Хос бичигтэн болох” гэсэн 2 арга хэмжээг тусгах.

8. Байгууллага болон хариуцсан мэргэжилтний гүйцэтгэлийн төлөвлөгөөнд сайдтай байгуулсан гэрээний 6, 22, 70 дугаартай заалт, 47 дугаартай заалтын 2 дахь хүрэх түвшин, чанарын үзүүлэлтийг нэмж тусгах, гэрээний заалтуудын шалгуур үзүүлэлт, суурь түвшин, хүрэх түвшинг сайтар нягталж засах,

3.

9. Сайдын гэрээний хэрэгжилтийн тайланг гаргахад холбогдох мэргэжлийн байгууллагуудаас шаардлагатай тоо мэдээллийг авч, нэгтгэн боловсруулж хэвших

10. Сайдын гэрээний хэрэгжилтийг урьдчилсан байдлаар байгууллагын түвшинд нэгтгэн дүгнэх, хэрэгжилт хангалтгүй байгаа заалтуудыг тодорхойлж сайжруулах ажил зохион байгуулах

11. Монгол улсын Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 600 дугаар тогтоолоор төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журмыг шинэчлэн баталсан. Албан хаагчид үүний дагуу хувийн хэргийг бүрдүүлэх

12. Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам, маягт, танилцуулга, албан тушаалын картыг хэрхэн шинэчлэгдсэн талаар албан хаагчдад мэдээлэл хүргэж, дутуу материалыг бүрдүүлэн авах ажлыг зохион байгуулж дарааллын дагуу эмх цэгцэд оруулах

13. Ажлын байрандаа эмх цэгцтэй зөвхөн ажилд ашиглах зүйлсээ ойр байлгаж, илүүц зүйлсийг цэгцлэх

14. Байгууллагын үйлчилгээний стандартыг чанд мөрдөх

Зөвлөмжийн дагуу гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган биелэлтийг 2023 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ДАРГА Ц.ГАНЧИМЭГ

